213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	296,071,300.00	268,219,950.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	7,999,900.00	7,999,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	60,663,100.00	60,559,042.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	430,158,200.00	399,881,597.00
223001	Бусад хөрөнгө	430,158,200.00	399,881,597.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	500,000,000.00	198,000,000.00
230001	Эргэж төлөгдөх зээл	500,000,000.00	198,000,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	23,256,941,800.00	22,649,712,734.74
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	18,101,520,000.00	17,794,471,536.64
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	17,688,844,100.00	17,381,795,446.64
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	412,675,900.00	412,676,090.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,547,357,800.00	4,430,588,109.01
320001	Орон нутгийн төсвөөс	4,547,357,800.00	4,430,588,109.01
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	608,064,000.00	424,653,089.09
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	555,624,400.00	424,653,089.09
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	52,439,600.00	0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	54,632,343.30
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	205,993,008.39

6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	14,137.00	14,369.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	32	32
610001	Төсвийн байгууллага	26	26
610002	Төсвөөс гадуур байгууллага	6	6
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	1,140.00	1,220.00
620001	Удирдах ажилтан	40	49
620002	Гүйцэтгэх ажилтан	807	860
620003	Үйлчлэх ажилтан	256	273
620004	Гэрээт ажилтан	37	38
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	11,825.00	11,897.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	8,848.00	9,283.00
630001	Төрийн өмчит ЕБС	8,679.00	8,589.00
630002	Хувийн ЕБС	169	694
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	2,977.00	2,614.00
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	2,682.00	2,614.00
631002	Хувийн өмчит СӨБ байгууллага	295	0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	1,140.00	1,220.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	14	14
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	700	763
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	5	4
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	42	42
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	333	350
650010	Гэрээт ажилтан	31	32
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	15	15

2.6. АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,126,808,849.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,039,604,182.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	952,763,309.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	295,076,906.00
210104	Урамшуулал	295,076,906.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,196,155.00
210201	Тэтгэврийн даатгал	34,196,155.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,788,676.00
210301	Гэрэл, цахилгаан	484,123.00
210302	Түлш, халаалт	2,216,173.00
210303	Цэвэр, бохир ус	88,380.00
2104	Хангамж, бараа материалын зардал	41,540,587.00

210401	Бичиг хэрэг	7,727,776.00
210402	Тээвэр, шатахуун	6,042,250.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,020,800.00
210404	Ном, хэвлэл	950,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,251,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	21,548,761.00
2105	Нормативт зардал	445,471,540.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	438,326,540.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,145,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	74,474,139.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	43,396,539.00
210602	Тавилга	15,561,000.00
210604	Урсгал засвар	15,516,600.00
2107	Томилолт, зочны зардал	7,972,000.00
210702	Дотоод албан томилолт	7,972,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,252,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,459,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	58,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,690,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,990,906.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,978,315.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	26,012,591.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	86,840,873.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	86,840,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	86,840,500.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	373
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжил төвлөрүүлэх шилжүүлэг	373
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	87,204,667.00
2200	Дотоод эх үүсвэрээр	87,204,667.00
223001	Бусад хөрөнгө	87,204,667.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,102,266,252.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,102,266,252.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	4,370,850.00
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	135,984,667.00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	923,819,695.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	38,091,040.00
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-24,542,597.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	24,542,597.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Улаангом сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ч.Мөнхтогтох гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Улаангом сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 130 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Шалгагдагч этгээд, түүний орчин ба дотоод хяналт

Улаангом сумын Засаг даргын эрхэм зорилго нь “Төрийн захиргааны байгууллагын манлайллыг дээшлүүлэх, хууль тогтоомж, Засгийн газар болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ хийх, үр дүнг үнэлж дүгнэх удирдлагыг цаг үеэ олсон зөвлөгөө, бүх үйлчилгээ мэдээллээр хангах иргэдэд төрийн үйлчилгээг хурдан шуурхай хүргэх” зорилго, зорилтыг хэрэгжүүлэн ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Малын тоо толгойн албан татварын тухай хууль
- Нийгмийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хууль
- Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор “төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”

Шалгагдагч этгээдийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Сумын нэгтгэсэн санхүүгийн тайланд мөрдөх тусгайлан баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй бөгөөд Сангийн яамнаас гаргасан бодлого шийдвэрүүдийг хэрэгжүүлэн и-баланс цахим программ хангамж ашиглан холбогдох хууль тогтоомж, Нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн, үйл ажиллагааны онцлогт тохируулан ашиглаж байна.

Улаангом сумын Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаангом сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар 128.6 сая төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөхгүйгээр нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 32,145.5 сая төгрөгийн 0.5 хувь буюу 160.7 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 128.6 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Улаангом сумын Засаг даргын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,433.4 сая төгрөг буюу 9.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	284.7	544.1	259.4
Авлага	1,044.3	1,555.2	510.9
Бараа материал	1,975.8	2,360.3	384.5
Үндсэн хөрөнгө	65,494.8	70,774.1	5,279.3
Нийт хөрөнгө	68,800.3	75,233.7	6,433.4
Өр төлбөр	65.9	116.8	50.9
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	68,734.4	75,116.9	6,382.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	68,800.3	75,233.7	6,433.4

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 284.7 сая, эцсийн үлдэгдэл 544.1 сая төгрөг болж, 259.4 сая төгрөгөөр өссөн нь байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 1,044.3 сая, эцсийн үлдэгдэл 1,555.2 сая төгрөг болж, 510.9 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь ковид-19 цар тахалтай холбоотой Эрүүл мэндийн даатгалын сан, Улаангом сумын цэцэрлэгүүд дээр оны төгсгөлд хийгдсэн худалдан авалтын хөрөнгө биетээр орж ирээгүйтэй холбоотой авлага үүссэнтэй байна.

3.5.3 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын дансны үлдэгдэл 2,360.3 сая төгрөг болж 384.5 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь Цогцолбор 1 дүгээр сургууль, Ахлах 3 дугаар сургууль, Засаг даргын тамгын газар, Өрхийн эрүүл мэндийн төвийн бараа материал нэмэгдсэнээс шалтгаалжээ.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн данс 70,774.1 сая төгрөг болж 5,279.3 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 471.9 сая, балансаас балансад шилжүүлэн авсан 22,555.9 сая, улсын төсвийн болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар авсан 6,662.7 сая, үнэ төлбөргүй хандиваар авсан 1,502.1 сая төгрөгөөр нэмэгдсэн, балансаас балансад шилжүүлсэн 22,599.7 сая, акталсан 1,515.2 сая төгрөгөөр хасагдсан байна.

3.5.5 Өр төлбөр

Өр төлбөрийн данс 116.8 сая төгрөг болж 50.9 сая төгрөгөөр өссөн байна.

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 75,116.9 сая төгрөг болж 6,382.5 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 17,210.6 сая төгрөгөөр буюу 48.3 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 1,531.5 сая төгрөгөөр буюу 5.0 хувиар өссөн байна.

3.5.7 Орлогын данс

Тайлант онд татварын орлого 1,780.8 сая, татварын бус орлого 1,559.9 сая, тусламж санхүүжилтийн орлого 26,196.7 сая, нийт 29,537.4 сая төгрөгийн үйл ажиллагааны орлого орсон байна.

3.5.8 Зардлын данс

Зардлын данстай холбоотой Төсвийн шууд захирагчид 379.5 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

Улаангом сумын Засаг даргын тамгын газар:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт заасныг зөрчиж Ухаалаг худгийн картын орлого 6.1 сая төгрөгийг авлага дансанд бүртгээгүй, түлш халаалтын зардлаас гарсан 0.8 сая төгрөгийг тээвэр шатахууны зардалд буруу бүртгэсэн алдааг аудитын явцад залрууллаа.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэгт “Сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 29 дүгээр зүйлд заасан нийтлэг бүрэн эрхээс гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 31.1.2 дахь заалтад “сум, дүүргийн Засаг дарга нэгээс илүүгүй орлогчтой байх бөгөөд орлогчийг тухайн Хурлын Тэргүүлэгчидтэй зөвшилцөн томилох, чөлөөлөх”, Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт “Төрийн албан хаагч хуульд зааснаас гадна дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно”, 39.1.2 дахь заалтад “албаны эрх мэдлээ хэтрүүлэх”, 39.1.3 дахь заалтад “хуульд нийцээгүй шийдвэр гаргах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэгт “Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 6.4.1 дэх заалтад “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасныг тус тус зөрчин Улаангом сумын Засаг даргын тамгын газар Засаг даргын орлогчийн 1 орон тоон дээр 2 орлогч ажиллуулж 16.1 сая төгрөгийн цалинг илүү олгосныг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосон.

Улаангом сумын 2 дугаар цэцэрлэг:

Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.4-д “Сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл сахилгын шийтгэлгүйд тооцно”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2.7-д “Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй” гэж заасныг зөрчин 0.3 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосонд төлбөрийн акт тогтоосон.

Улаангом сумын Ерөнхий боловсролын 2 дугаар цогцолбор сургууль:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 дэх хэсэгт “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэж заасныг зөрчин он дамжин хэрэгжиж буй төслийн үлдэгдэл санхүүжилт 4.5 сая төгрөгийг төслийг хариуцан гүйцэтгэж буй 2 багшийн хувийн дансанд шилжүүлж зардлаар бүртгэснийг аудитын явцад санхүүгийн тайланд авлагаар тусгаж залруулсан.

Улаангом сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургууль:

Улаангом сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургууль нь нүүрс худалдан авах тендер шалгаруулахдаа хамгийн бага үнэтэй буюу 1 тонн нүүрсийг 0.4 сая төгрөгөөр нийлүүлэх үнийн санал ирүүлсэн компанийг шалгаруулсан ч 1 тонн нүүрсийг 0.6 сая төгрөгөөр худалдан авах гэрээ байгуулж 370.6 тонн нүүрс худалдан авч төрд 3.7 сая төгрөгийн хохирол учруулсан зөрчилд төлүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

Улаангом сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр цогцолбор сургууль:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 дэх хэсэгт “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэж заасныг зөрчин он дамжин хэрэгжиж буй төслийн үлдэгдэл санхүүжилт боловсрол, шинжлэх ухааны яамны “Боловсрол чанарын шинэчлэл” төслийн хүрээнд хийгдээгүй ажлын санхүүжилт 1.8 сая төгрөгийг сургуулийн нярвын дансанд шилжүүлснийг санхүүгийн тайланд авлага тусгуулан залруулга хийлгэв.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалтад “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг зөрчин цалингийн зардлаас нийгмийн даатгалын шимтгэлд 15.1 сая, ашгийн татварт 7.1 сая, Нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас нийгмийн даатгалын шимтгэлд 14.2 сая төгрөгийг илүү шилжүүлж нийгмийн даатгалын авлага 29.4 сая, татварын авлага 7.1 сая, нийт 36.5 сая төгрөгийг авлага үүсгэсэнд цаашид өр авлага үүсгэхгүй байх зөвлөмж өгсөн байна.

Увс аймгийн Ерөнхий боловсролын лаборатори 1 дүгээр цогцолбор сургуулийн багш Л.Баяржаргалд сахилгын шийтгэл тооцох хугацаа дуусаагүй байхад 3, 4-р улирлын үр дүнгийн урамшуулалд нийт 0.4 сая төгрөг олгосон байсанд төлбөрийн акт тогтоосон.

Увс аймгийн “Улаангом тохижилт үйлчилгээний” ОНТҮГГазар:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтад “Үнэн зөв байх”, 14 дүгээр зүйл 14.4 дэх хэсэгт “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2 дахь заалтад “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, 14.4.6 дахь заалтад “бүх зардал” гэж заасныг тус тус зөрчсөн дараах алдаа зөрчлүүдийг залруулсан. Үүнд:

-Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн 266.0 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тайлагнаагүй.

-Ажилтанд өгсөн 0.1 сая төгрөгийн тэтгэмжийн зардлыг дутуу илэрхийлж санхүүгийн тайланд мөнгөн хөрөнгийн үлдэгдлээр тайлагнаагүй.

-Гэрний дагуу хог ачих, самбарын түрээсийн үйлчилгээ үзүүлсэн харилцагч нараас авах 5.8 сая төгрөгийн төлбөрийг санхүүгийн тайланд авлагаар тайлагнаагүй алдаа зөрчлийг залруулсан.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 5.5 дахь заалт “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтад “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, Монгол улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4 дэх заалтад “энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх” гэж заасныг тус тус зөрчин Улаангом тохижилт үйлчилгээ ОНТҮГ-

ын даргын 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн А/26 тоот тушаалаар ажилтнуудад нормын хувцас олгох шийдвэр гаргаж 7 ажилтанд тус бүрт 0.15 сая нийт 1.0 сая төгрөгийг ажилтнуудын харилцах данс руу шилжүүлэн өгсөнд төлбөрийн акт тогтоосон.

Нягтлан бодох бүртгэлийн 13.7 дахь хэсэгт “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар “Жишиг норм батлах тухай” тушаалыг хэрэгжүүлэхгүйгээр тээвэр шатахууны зардлаас 36.4 сая төгрөгийн 15163 литр шатах тослох материалыг зарцуулахдаа замын хуудас хөтлөөгүй, зарцуулалтын тооцоо бодохгүй хяналтгүйгээр зарцуулсанд албан шаардлага өгсөн.

Увс аймгийн Насан туршийн боловсрол, хүүхдийн хөгжлийн төв:

Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.4 дэх хэсэгт “Сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл сахилгын шийтгэлгүйд тооцно”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2 дугаар зүйлийн 2.7 дахь хэсэгт “Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй” гэж заасныг зөрчин Насан туршийн боловсрол, хүүхдийн хөгжлийн төвийн үйлчлэгч Д.Бадамжавд сахилгын шийтгэл тооцох хугацаа дуусаагүй байхад 3, 4-р улирлын үр дүнгийн урамшуулалд нийт 241.9 мянган төгрөг олгосныг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосон.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Улаангом сумын 2021 оны төсвийг сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 2/05 дугаар тогтоолоор 3,775.4 сая төгрөгөөр баталж 2021 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн 3/01 дүгээр тогтоолоор тодотгол хийж анх баталсан дүнгээс 148.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 3,923.4 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,923.4 сая төгрөгийн төсөв баталснаас 2,691.2 сая төгрөгийг улсын төсвөөс, 990.3 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 41.7 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 200.2 сая төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,691.2 сая, орон нутгийн төсвөөс 990,3 сая, Эрүүл мэндийн даатгалын сангаас 39.2 сая, төгрөгийн санхүүжилт авч, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 119.1 сая, нийт 3,839.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 3,749.7 сая төгрөгийг зарцуулж улсын төсөвт 50.9 сая, орон нутгийн төсөвт 34.0 сая, нийт 84.9 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,749.7 сая төгрөг буюу 95.5 хувьтай байгаа нь зардлыг 84.9 сая төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Улаангом сумын ИТХ-ын 2021 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн сумын 2021 оны тодотгосон төсөв батлах тухай 03/01 дүгээр тогтоолд зааснаар Улаангом сумын Засаг дарга тайлант онд 112.9 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 118.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 104.4 хувиар биелүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас 348.4 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1.2 сая, хандив тусламж 6.7 сая нийт 356.4 сая төгрөгийн орлого орсныг зарцуулалтын эрх нээлгэн 350.8 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/108 дугаар чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Улаангом сумын Засаг даргын хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байсан тул Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахаар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 157 мэдээллээс хугацаандаа оруулсан 155, байршуулах хугацаа хоцроосон 1, байршуулах хугацаа болоогүй 1 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар “Улаангом хот тохижилт” ОНТҮГ-ын үндсэн үйл ажиллагааны орлогыг тулган баталгаажуулах шаардлагатай. Цогцолбор 1 дүгээр сургуулийн цалингаас суутгасан хувь хүний орлогын албан татварын 30.8 сая төгрөгийг 100150000901 тоот Суутган-1 дансанд шилжүүлэхгүйгээр хувь хүнээс суутгасан орлогын албан татварын 100151900912 тоот дансанд шилжүүлсэн байна. Дараагийн аудитаар анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

3.12 Аудитын явцад хэрэгжүүлсэн ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Улаангом сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 22 төсвийн байгууллага, 1 ОНТҮГ-т дүгнэлт гарган, 3 тусгай санг түүвэрт хамруулан 2021 оны санхүүгийн тайланд аудит хийж баталгаажуулсан. Мөн нэгтгэлд хувийн сургууль, цэцэрлэг, Улаангом сумын баг, Өрхийн эмнэлэг, төрийн сан, бусад санг хамруулан нэгтгэсэн.

Аудитад хамрагдсан төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, 20 санал дүгнэлт санал дүгнэлт өгсөн байна.

Харьяа байгууллагуудад хийсэн аудитаар нийт 379.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 285.4 сая төгрөгийн 4 алдааг залруулж, 21.4 сая төгрөгийн 5 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 36.4 сая төгрөгийн 1 албан шаардлага, 36.5 сая төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Улаангом сумын Засаг даргын тамгын газар	2	23.2	1	7.1	1	16.1				
2	Улаангом сумын 2-р цэцэрлэг	1	0.9			1	0.9				
3	Улаангом сумын Ерөнхий боловсролын 2-р сургууль	1	4.5	1	4.5						
4	Улаангом сумын Ерөнхий боловсролын 5-р сургууль	1	3.7			1	3.7				
5	Улаангом сумын Ерөнхий	3	38.7	1	1.8	1	0.4			1	36.5

	боловсролын 1-р сургууль										
6	Увс аймгийн "Улаангом тохижилт үйлчилгээ" ОНТҮГ	3	308.5	1	272.0	1	0.1	1	36.4		
7	Насан туршийн боловсрол, хүүхдийн хөгжлийн төв	1	0.2			1	0.2				
ДҮН		12	379.7	4	285.4	5	21.4	1	36.4	1	36.5

4. Аудитын илрүүлэлт

4.1 Залруулсан алдаа

Аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

/сая төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Улаангом сумын Засаг дарга	0	0.0								
НИЙТ		0	0.0								

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН: АУДИТОР

/Ч.МӨНХТОГТОХ/

2022 оны 03 сарын 25-ны өдөр